



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2013 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 424

Улаанбаатар хот

**Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа
лабораторийн бүтэц, дүрмийг
батлах, байгуулах тухай**

Монгол улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 8.1.1, 8.1.4, 15.1.12, Монгол улсын эрүүл мэндийн лабораторийн тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги (2010-2015)-ийн 1.2, 2.1, ЭМЯ-ны Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлийн 2013 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлын 05 тоот шийдвэрийг үндэслэн, эрүүл мэндийн лабораторийн тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх, лавлах тусlamж, чанарын баталгааг хангах зорилгоор ТУШААХ нь:

Нэг. “Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лаборатори”-ийг байгуулж, “Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лабораторийн үйл ажиллагааны дүрэм”-ийг нэгдүгээр, “Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лабораторийн бүтэц, зохион байгуулалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лабораторийн үйл ажиллагааг дүрмийн дагуу зохион байгуулж ажиллахыг холбогдох эрүүл мэндийн байгууллага (Үндэсний оношлогооны төв, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, Эмгэг Судлалын Үндэсний Төв, Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төв, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв)-ын удирдлагуудад үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лабораторитой нэгдмэл үйл ажиллагааг ханган дүрэмд заасан үүргийг биелүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лабораторийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлын төсөв, хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Бодлого төлөвлөлтийн газрын дарга (Ц.Цолмонгэрэл)-т үүрэг болгосугай.

Тав. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (Я. Буянжаргал)-д даалгасугай.


Зургаа. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.

САЙД

Н.УДВАЛ



002813



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 дугаар сарын 11-ны өдрийн 11 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДСЭН ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ (төсөл)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лаборатори нь /цаашид Лавлагаа лаборатори гэх / онош зүй, халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн лабораторийн тусlamж үйлчилгээний арга зүйн удирдлага, лавлах үйлчилгээ, чанарын баталгаажилтыг хариуцан гүйцэтгэж хүн амд үзүүлэх лабораторийн тусlamж үйлчилгээг сайжруулах чиг үүрэг бүхий байгууллага байна.

1.2. Лавлагаа лаборатори нь хуулийн өмнө хариуцлага хүлээх хуулийн этгээд байна.

1.3. Лавлагаа лаборатори нь үйл ажиллагаандaa Эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, холбогдох бусад хууль болон энэхүү дурмийг баримтлан ажиллана.

1.4. Лавлагаа лабораторийн зорилго нь хүн амд үзүүлэх лабораторийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.

1.5. Лавлагаа лаборатори нь улс, орон нутгийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, өөрийн орлого, хандив, зээл тусlamж зэрэг эх үүсвэрээс санхүүжинэ.

1.6. Лавлагаа лаборатори нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.7. Лавлагаа лабораторийн батлагдсан бүтцийг өөрчлөх, татан буулгах асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

Хоёр. Лавлагаа лабораторийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Лавлагаа лаборатори нь чиглэлийн салбар лавлагаа лабораториудаас бүрдэх ба чиглэлийн лавлагаа лабораториуд нь дараах байршилтай байна. Үүнд: Эмнэлзүйн лавлагаа лаборатори болон Удирдлага, зохион байгуулалтын хэсэг Үндэсний оношлогооны төв, Халдварт өвчиний лавлагаа лаборатори нь Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын лавлагаа лаборатори нь Эмгэг судлалын үндэсний төв, Зоонозын халдварын лавлагаа лаборатори нь Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Транфузиологийн лавлагаа лаборатори нь Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн халдварт бус өвчиний лавлагаа лаборатори нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв дээр тус тус байрлах ба уг төвүүдийн харьяанд үйл ажиллагаагаа явуулна.

2.2. Үндэсний лавлагаа лаборатори нь ЭМЯ, ЭМЯ-ны дэргэдэх Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран ажиллана.

2.3. Лавлагаа лаборатори нь үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байр, багаж, тоног төхөөрөмж, хэрэгсэл, урвалж, оношлуур болон мэргэшсэн боловсон хүчинээр хангагдсан байна.

2.4. Лавлагаа лаборатори нь тус бүтцийн алсын хараа, хэтийн зорилтыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, чиглэлийн лавлагаа лабораториудын нэгдмэл үйл ажиллагааг хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна.

2.5. Удирдах зөвлөл нь чиглэлийн лавлагаа лабораториудын эрхлэгч нараас бүрдэх ба Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.6. Чиглэлийн лавлагаа лабораториудын эрхлэгч нарыг Лавлагаа лабораторийн захиралтай зөвшилцсөний үндсэн дээр харьяаллын үндэсний төвийн захирал томилж, чөлөөлнө.

2.7. Лавлагаа лабораторийн захирал нь Үндэсний оношлогооны төв дээрх Эмнэлзүйн лавлагаа лаборатори болон Удирдлага зохион, байгуулалтын хэсгийн захирал байх ба эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах ба Лавлагаа лабораторийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө бүрэн хариуцана.

2.8. Лавлагаа лабораторийн захирлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

2.9. Чиглэлийн лавлагаа лабораториудын бүтэц зохион байгуулалт, орон тоог Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр харьяа Төвийн захирал батална.

2.10. Лавлагаа лабораторийн үйл ажиллагааны дүрэм, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Гурав. Лавлагаа лабораторийн үүрэг

3.1. Бүх шатны лабораториос ирсэн сорьцонд лавлагаа шинжилгээ хийж, шинжилгээний зөрүү, маргааныг шийдвэрлэх,

3.2. Улсын хэмжээнд чанарын гадаад үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, гадаад үнэлгээний нэгдсэн сүлжээг удирдаж, хяналт тавьж ажиллах,

3.3. Батлагдсан жагсаалтанд орсон илгээмж шинжилгээг хийж гүйцэтгэх,

3.4. Бүх шатны лабораториос тайлан мэдээ авч, улсын хэмжээнд хэрэгжсэн лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан мэдээг гаргах,

3.5. Шинжилгээний заавар журам, СҮЗ, гарын авлага боловсруулах, шинэчлэх, баталгаажуулах үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих,

- 104
- 3.6. Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан мэргэжлийн сургалтын урт ба богино хугацааны хөтөлбөр тогтмол хэрэгжүүлэх,
 - 3.7. Лабораторийн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх,
 - 3.8. Лабораторийн салбарт технологийн дэвшил нэвтрүүлэх, олон улсын хэмжээнд гарсан шинэ технологийг мэдээлэх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах,
 - 3.9. Лабораторийн салбарыг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэх, дараагийн шатны стратеги боловсруулах, батлуулах ажилд оролцох,
 - 3.10. Салбарын хэмжээний хүний нөөц, ханган нийлүүлэлт, оношлуур тоног төхөөрөмжийн чанар стандартад хяналт тавьж, нэгдсэн мэдээллийн сан бий болгох

Дөрөв. Лавлагаа лабораторийн эрх


- 4.1. Эрүүл мэндийн лабораторийн хөгжил, салбарын эрх ашгийг шийдвэрлэхэд шаардлагатай эрхзүйн баримт бичгүүдийг боловсруулахад оролцох, санаачлах, мөрдүүлэх,
- 4.2. Төрийн захиргааны болон холбогдох байгууллагуудад лабораторийн тусlamж, үйлчилгээний талаар асуудал дэвшүүлж шийдвэрлүүлэх,
- 4.3. Улсын хэмжээнд лабораториудын үйл ажиллагаанд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, ангилал, стандартчиллын дагуу шинжилгээг ижилтгэн жигдүүлэх,
- 4.4. Лавлагаа лабораториос хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хүлээгдсэн үр дүнд хүрэхгүй тохиолдолд шалтгааныг тодруулж, асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх,
- 4.5. Санхүүгийн чадвараа дээшлүүлэх зорилгоор төлбөрт үйлчилгээ явуулах,
- 4.6. Гадаад орны адил үйл ажиллагаа явуулдаг байгууллага, олон улсын байгууллагуудтай хуулийн хүрээнд хамтран ажиллах

Тав. Лавлагаа лабораторийн бүтэц, үйл ажиллагаа


- 5.1. Лавлагаа лаборатори нь эрүүл мэндийн үндсэн чиглэлүүдийн лавлагаа лабораториудаас бүрдсэн нэгдмэл бүтцээр үйл ажиллагаа явуулна.
- 5.2. Чиглэлийн лавлагаа лабораториуд нь харьяа үндэсний төвүүдийн дэргэд үйл ажиллагаагаа явуулна.
- 5.3. Лавлагаа лабораторийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь төрөл бүрийн лавлагаа үйлчилгээ, баталгаажилт байна.
- 5.4. Лавлагаа лаборатори нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын тишүүний баталсан Лавлагаа лабораторийн үйл ажиллагааны журмыг мөрдөн ажиллана.

Өрүүл мэндийн сайдын 2013 оны тусгаар сарын...ны өдрийн тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДСЭН ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН БҮТЭЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




1.Үндэсний онцлогооны төв дахь Нийгдэн лавлагaa лабораторийн бүтэй,
зохион байгуулалт, Үйл ажиллагааны чиглэл



Tabjaraa jaagopatorpinn 67ru

Tabjaraa jaagopatorpinn Yru
akjigjarrarabi yru

**2.ХӨСҮТ дахь халдварт өвчний лавлагaa лабораторийн бүтэц,
зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл**



**3.ЭСҮТ дахь эмгэг судлалын лавлагаа лабораторийн бүтэц,
зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл**

ЭМГЭГ СУДЛАЛЫН ЛАВЛАГАА
ТОВ ЛАБОРАТОРИ

Эд эсийн лабораторийн төвийн
тасаг
(КНТЭ, БЗД, ЧД, СБД-ийн
нэгдсэн эмнэлгүүд)

Эд эсийн лабораторийн
ЭХЭМҮТӨВИЙН ДЭРГЭДЭХ ТАСАГ
(ЭХЭМҮТ, ТӨРЕХ ЭМНЭЛГҮҮД,
ХҮҮХДИЙН ЭМНЭЛГҮҮД)

Эд эсийн лабораторийн
УГТЭ-ийн дэргэдэх тасаг
(СХД, ХУД-ийн нэгдсэн
эмнэлгүүд)

Эд эсийн лабораторийн
ХСҮТӨВИЙН ДЭРГЭДЭХ ТАСАГ
(ХСҮТ, ХӨСҮТ, ХУВИЙН
ХЭВШИЙН ЭМНЭЛГҮҮД ХАМААРНА)

- Хөдөө, аймаг орон нутгийн эмгэг судлалын эд, эсийн лабораториудын үйл ажиллагааг улдуулан зохицуулах
- Эмгэг судлалын илгээмж болон лавлагаа шинжилгээ хийж гүйштгэх
- Лавлагаа тусlamжийн үйл ажиллагаа хэрэгжүүлж, сургалт зохион байгуулах
- Эмгэг судлалын чиглэлийн лабораториудын чанарын гадаад үнэлгээнний үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эмчэг эд, эсийн лабораторийн онош зүйн туслаамж үзүүлж байгаа бүх хэвлэлийн эмнэлэг, лабораторийн мэргэжлийн үнэлгээ хийж, багалгаажилт гаргах, бүртгэл хөтөлж
- УБ хотын болон аймгийн нэгдсэн эмнэлгүүд, бусийн оношлогооны төвүүдэд зайн оношлогоогоор эд, эсийн бэлдмэлийн чанарын хянант, оношийн багалгаажилт, эмгэг судлалын мэргэжлийн зөвлөлөө, клиник эмтэг судалын мэдээллийг тогтолцожуулж, багалгаажуулах
- Эмгэг эд, эсийн лабораториудад сорьц шуглуулах, бэлтгэн боловсруулах, шинжлэх, хадгалахад шаардлагатай олон улсын стандартад тохирсон багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах

4.3 ОСҮТ дахь зоонозын хадварын лавлагаа лабораторийн бүтэц, зохион байгуулалт, Үйл ажиллагааны чиглэл



Зоонозын хадварын
лавлагын лаборатори

Нийн судалын лаборатори


Вирус судалын
лаборатори

Этгэл биетэн судалын
лаборатори

Шимэгч судалын
лаборатори

- Эмнэл зүйн (шус, ийлдэс, биологийн шингэн, эд, эс, наалдац), гадаад орчны, хадвар агуулагч, дамжуулагч амьтны (үе хөтөн, мэрэгч, амьтад) сорьц, бичил биетний өсгөвөр (иин, вирус, эгэл биетэн), эрэг сорьц (эсрэгтөрөгч, эсрэгбие) болон биотерроризмын холбогдолтой сорьсонд лавлах шинжилгээ хийж багалгаажуулах
- Шинжилгээний лавлах технологи, лабораторийн шинжилгээ, оношлогооны стандарт Уйлдлийн ажилбар, арга зүйн заавар, зөвлөмжийг нэлдээн журмаар боловсруулах, тутгэх Шинжилгээдэхүүн, биобэлдмэлийн олон улсын итгэмжлэгдсэн лавлаагаа лабораториор шинжилгээ, оношлогооны дүгнэлтийг баталгаажуулах;
- Багалгаажуулсан эрэг сорьц, өсгөврийн сан байгуулах;
- Лабораторийн чанаарын гадаал, дотод хяналтын сүлжээний тогтолцоог бурдуулэх, улсын хэмжээнд лабораторийн чанаарын нэгдсэн тайлан гаргах, харьцаалын лабораториудад энэ чиглэлээр зөвлөгөө өгөх, сургалт явуулах
- Олон улсын лабораторийн чанаарын хяналтын сүлжээнд хамрагдах
- Зоонозын хадварын лабораторийн хүний ноөцийн хэрэгцээг тодорхойлох, хөгжлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
- Зоонозын хадварын лабораторийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, оноштуур урвалжийн зохион байгуулалтын нэгдсэн үйл ажиллагааг боловсруулах
- Чиглэлийн лабораторийн үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн санг бурдуулэх
- Биоауулгүй ажиллагааны лавлагаа, баталгаажилтын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- Судалгаа, туршилт, Үйлдвэрэлийн үйл ажиллагааг ондөр чанартай хийж гүйцэтгэх

**5. Трансфузиологийн лавлагага лабораторийн бүтэц,
зохион байгуулалт, Үйл ажиллагааны чиглэл**



111

6. Нийгмийн эрүүл мэндийн халдварт бус өвчний лавлагага лабораторийн бүтэц, зохион байгуулалт, Үйл ажиллагааны чиглэл



Микробиологийн лаборатори

Хүрээлэн буй орчны
лаборатори

Шим тэжээлийн лаборатори

Клиник химийн лаборатори

- Хүрээлэн буй орчны болон хоол тэжээлийн байдлыг тогтоох шинжилгээ, мөн орчны болон хоол тэжээлийн нэлээнд хүний эрүүл мэндийн үнэлгээний шинжилгээг хийж гүйцэтгэх
- Холбогдох шинжилгээний аргуудын стандарт Уйлдлийг боловсруулах
- Холбогдох лабораториудад мэргэжлийн болон шинжлэх ухааны зөвлөгөөгөөг сургарт явуулах
- Гадаад, дотоодын хамтын ажиллагаа хэрэгжүүлэх
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэх